БАТЛАВ:

| ЗАХИАЛАГЧ | ГҮЙЦЭТГЭГЧ |
|---|---|
| ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ | ИРМҮҮН БАР ХХК-ИЙН ЗАХИРАЛ |
| ................... Ц.БИЛЭГТСАЙХАН | ................... З.АЛТАНГЭРЭЛ |

# БАРОКАМЕРЫН ӨРӨӨНИЙ УРСГАЛ ЗАСВАРЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар АГ/22/98

Улаанбаатар хот

Нэг талаас: Халдварт өвчин судлалын үндэсний төвийг төлөөлж, Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан цаашид /захиалагч тал гэх/,

Нөгөө талаас: 5565162 регистрийн дугаартай, Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, 17-54 тоотод байрлах Ирмүүн бар ХХК-ийг төлөөлж менежер З.Баянмөнх /цаашид Гүйцэтгэгч гэх/ Монгол улсын Иргэний хуульд заасан нийтлэг үндэслэл болон мөн хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалтыг үндэслэн хоёр байгууллагын даргын олгож, зөвшөөрсөн эрх хэмжээний хүрээнд доорх нөхцлүүдийг харилцан тохиролцож 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээний зорилго нь Халдварт өвчин судлалын үндэсний төв нь сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасгийн барокамерын өрөөний урсгал засварын ажил /цаашид ажил гэх/-ыг захиалж, гүйцэтгүүлэх, Ирмүүн бар ХХК нь төвийн захиалсан ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон харилцаа болон гэрээний талуудын эрх зүйн байдлыг тогтоож зохицуулахад чиглэгдэнэ.

1.2. Энэхүү гэрээ нь Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний бичиг баримт" гэх). Үүнд:

- 1.3.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 1.3.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 1.3.3 Үнийн санал
- 1.3.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.3.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.3.6 Техникийн тодорхойлолт;
- 1.3.7 Зураг;
- 1.3.8 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 1.3.9 Санхүүжилтийн хуваарь;
- 1.3.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

1.4. Энэхүү гэрээ нь ажлыг захиалж, гүйцэтгэх талаар гэрээ байгуулахаас өмнөх шатанд хэлэлцэх, зөвлөлдөх, тодруулга, тайлбар авах, өгөх зэргээр талуудын үйлдсэн бүх хэлцлийг эцэслэн нэгтгэж, тохиролцсон албан ёсны эрх зүйн баримт бичиг болно.

1.5. Хэрэв гэрээний салшгүй хэсэгт тооцохоор энэхүү гэрээний 1.3 дахь хэсэгт заасан бичиг баримтууд өөр хоорондоо зөрчилдвөл мөн хэсэгт заасан дарааллын дагуу өөр хоорондоо нь уялдаатай байдлаар ач холбогдол өгч, шийдвэрлэнэ.

## ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Гүйцэтгэгчтэй байгуулсан энэхүү гэрээгээр тогтоосон графикт хугацаанд захиалсан ажлыг нэр, төрөл, тоо хэмжээгээр хүлээн авах ба тогтоосон хугацаанд ажлыг гүйцэтгэхийг гүйцэтгэгчээс шаардана.

2.2. Захиалагч нь ажлыг төвийн шаардлага тавьсан техникийн тодорхойлолтод заасан шаардлагатай тохирч байгаа эсэхийг шалган хүлээж авна. Хэрэв гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил төвөөс шаардсан техникийн тодорхойлолттой тохирохгүй бол хүлээн авахаас татгалзана.

2.3. Захиалгат ажлыг хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор үнийг нь төлнө.

2.4. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын бүх нэр төрлийг 100 хувь худалдан авах ба шаардлагатай тохиолдолд ажлын үнийг өсгөхгүйгээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх хэсгийг үндэслэн гэрээний анхны үнийн дүнгийн 15 хүртэл хувиас хэтрүүлэхгүйгээр ажлын тоо хэмжээг нь нэмэгдүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд гэрээнд нэмэлт оруулж талууд баталгаажуулах бөгөөд энэхүү нэмэлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

2.5. Халдварт өвчин судлалын үндэсний төвд шинээр нэвтэрч буй технологи, тухайн жилийн өвчлөлийн байдал, төсөв санхүүгийн эрсдэлтэй байдал, давтагдашгүй бусад хүчин зүйл зэрэг захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагад танилцуулсаны үндсэн дээр гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын тоо хэмжээг гэрээний анхны үнийн дүнгийн 15 хүртэлх хувиар бууруулж болно. Энэ тохиолдолд гэрээнд оруулах өөрчлөлтийг талууд албан ёсоор баталгаажуулах бөгөөд гэрээний өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

2.6. Гэрээгээр гүйцэтгэвэл зохих ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл хуваарийн дагуу гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд захиалгат ажлыг гүйцэтгэх хуваарьт өдрийн дараагийн өдрөөс эхлэн гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгээс энэ гэрээний 5.4-д заасан алдангийг тооцно.

2.7. Гүйцэтгэгч талын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавих албан тушаалтны мэдээлэл, тайланг сар бүр танилцан зөвлөмж, чиглэл өгч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, холбогдох мэдээллийг зохих журмын дагуу худалдан авах ажиллагааны цахим системд оруулна.

2.8. Хуулиар тогтоосон үндэслэл, эрх хэмжээний хүрээнд гэрээг цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гүйцэтгэгчид хүргүүлнэ.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Захиалагчийн захиалсан ажлыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох гүйцэтгэх ажлын жагсаалт болон хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

3.2. Захиалагчтай тохиролцож энэхүү гэрээгээр тогтоосон нөхцөл шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэх ба хүлээлгэн өгөх үед шаардлага хангаагүй ажлыг захилагчийн тогтоосон хугацаанд яаралтай нөхөн гүйцэтгэнэ.

3.3. Захиалагчтай тохиролцон энэхүү гэрээний салшгүй хэсэг болох захиалж, гүйцэтгүүлэх ажлыг жагсаалтад заагдсан нэршлээс өөр төрлийн ажлаар орлуулж гүйцэтгэхгүй байх үүрэг хүлээнэ.

3.4. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэхээр тохиролцсон хуваарьт хугацааг хэтрүүлсэн тохиолдолд ажлыг гүйцэтгэвэл зохих өдрийн дараагийн өдрөөс эхлэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгээс энэ гэрээний 5.4-д заасан алданги төлнө.

3.5. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын чанарын доголдол болон давагдашгүй хүчин зүйлд тооцохоор энэ гэрээний 3.4-д зааснаас бусад тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг хэтрүүлсний улмаас хүний амь нас эрсдсэн, эрүүл мэндэд хохирол учирсан бол үр дагаврыг бүрэн хариуцна;

3.6. Захиалгат ажлыг захилагчтай тохиролцон баталсан хуваарийн дагуу тухайн сарын ажлын эхний 5 хоногт багтаан гүйцэтгэнэ;

3.7. Гүйцэтгэгчийн хүсэл зоригоос шалтгаалаагүй урьдчилан харах боломжгүй байсан зайлшгүй нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх ажлын нэр төрөл,- тоо хэмжээ өөрчлөгдөх болон захиалгат ажлыг хуваарьт хугацаанд гүйцэтгэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд нөхцөл байдал үүссэнээс хойш 24 цагийн дотор захиалагч талд мэдэгдэнэ.

3.8. Энэ гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй ба өөрөө гүйцэтгэнэ.

3.9. Захиалагч талыг гэрээний үүргээ биелүүлэхийг болон гүйцэтгэсэн ажлынхаа үнийг нэхэмжилж шаардах эрхтэй.

3.10. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал тавих эрх эдэлнэ.

## ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан 2022 оны 08 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд үйлчилнэ.

4.2. Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр ижил хууль зүйн хүчин чадалтай байна.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ,ТҮҮНИЙГ ТӨЛӨХ

5.1. Талуудын тохиролцсоноор Ирмүүн бар ХХК-иас Халдварт өвчин судлалын үндэсний төвд захиалгаар гүйцэтгэх ажлын нийт үнэ **27,508,822** (*хорин долоон сая таван зуун найман мянга найман зуун хорин хоёр*) төгрөг байна.

5.2 Гэрээний үнийн дүнгээс 2022 онд гүйцэтгэх ажлын дүн 27,508,822 төгрөг байна.

5.3 Захиалагч нь засварын ажил дуусгаж хүлээж авсаны дараа нийт санхүүжилт болох 27,508,822 төгрөгний санхүүжилтыг шилжүүлж тооцоог дуусгана.

5.4. Захиалагч ажлыг хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор үнийг нь төлнө.

5.5. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг нэр төрлөөр, тоо хэмжээгээр дутуу гүйцэтгэсэн, эсхүл хуваарийн дагуу гүйцэтгээгүй, хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээт ажлыг гүйцэтгэвэл зохих хуваарьт өдрийн дараагийн өдрөөс эхлэн гэрээний үнийн дүнгээс хоног тутам 0.05 хувийн алданги тооцон гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна.

## ЗУРГАА. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

6.1. Энэхүү гэрээний хавсралтад заасан гүйцэтгэх ажлын нэг бүрийн үнэ нь энэ гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд өөрчлөгдөхгүй байх нөхцөлийг талууд хатуу мөрдөнө.

6.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан үндэслэл, журмыг дагаж мөрдөнө.

6.3. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд энэхүү гэрээгээр талуудын тохиролцон тогтоосон захиалгаар гүйцэтгэх ажлын нэр төрөл, тоо хэмжээг өөрчлөхгүй байхыг эрмэлзэнэ. Өөрчлөх зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол ажлын 2 хоногт багтаан нөгөө талдаа мэдэгдэж, ажлын 5 хоногийн дотор талууд асуудлыг зөвшилцөн шийдвэрлэж, шийдвэрийг бичгээр үйлдэн баталгаажуулна. Талуудын гаргасан шийдвэр гэрээний салшгүй хэсэг болох тул талууд гаргасан шийдвэрийн дагуу хүлээсэн үүргээ гэрээний үүргийн нэг ижил биелүүлнэ.

6.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь хэсэгт заасны дагуу суурь үнэ огцом өөрчлөгдсөн болохыг Засгийн газар, эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний үнэд тохируулга хийнэ.

## ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээний 4.1-д заасан хугацаа дууссан өдөр энэ гэрээний үйлчлэл дуусгавар болно.

7.2. Гэрээний аль нэг тал татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагаа дуусгавар болж гэрээний үүрэг өөр бусад этгээдэд шилжээгүй тохиолдолд холбогдох байгууллагын шийдвэр гарсан өдөр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

7.3. Гэрээг хугацааны өмнө дараах үндэслэлээр цуцалсан тохиолдолд гэрээ хугацааны өмнө дуусгавар болно. Үүнд:

7.3.1. Гүйцэтгэгч тал чанарын шаардлага хангахгүй ажлыг гүйцэтгэсний улмаас үйл ажиллагаанд хохирол учирсаныг мэдэгдсэн байхад энэ зөрчлийг давтан гаргасан;

7.3.2. Энэ гэрээгээр гүйцэтгэхээр заасан ажлыг өөр төрлийн ажлаар орлуулан нийлүүлэхээр ирүүлснийг дахин гаргахгүй байх талаар төвөөс бичгээр мэдэгдэл хүргүүлсэн боловч зөрчлөө давтан гаргасан;

7.3.3. Гүйцэтгэгч тал ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүйгээс төвийн тусламж, үйлчилгээний хэвийн байдал алдагдаж үйлчлүүлэгчийн хохироосон нь төвийн чанар, дотоод хяналтын албаны болон холбогдох төрийн мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын дүгнэлтээр тогтоогдсон;

7.3.4. Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгэсэн ажлын үнийг төлөх хугацааг удаа дараа хэтрүүлж, гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдох асуудлаар албан бичиг буюу телекс, цахилгаан болон факсаар харилцана.

8.2. Энэхүү гэрээний хэрэгжилтийг гэрээ дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан талуудын төлөөлөл бүхий бүрэлдэхүүн дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

8.3.Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгааны улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүсэн гарах үр дагаврыг хариуцахгүй.

## ЕС. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

9.1. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд талуудын хооронд үүссэн маргааныг аль болох зөвшилцөн шийдвэрлэнэ.

9.2. Хэрэв зөвшилцөн шийдвэрлэж чадахгүй бол шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

***ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:***

Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

Д.Баярсайхан

..............................

Хангамж, үйлчилгээ, инженерийн технологийн албаны дарга

Н.Батням

..............................

ХАЯГ: УБ-48, Баянзүрх дүүрэг, 14-р хороо Нам-Ян-Жүгийн гудамж

УТАС: 451185, 453994
Харилцагч банкны нэр: Төрийн сан
Дансны дугаар: 100900020010
Регистрийн дугаар: 9077901

***ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:***

Ирмүүн бар ХХК-ний менежер

З.Баянмөнх

..............................

ХАЯГ: Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, 17-54 тоот

УТАС: 88119115, 88108490

Харилцах банкны нэр:
Худалдаа хөгжлийн банк

Дансны дугаар: 417027994

Регистрийн дугаар: 5565162

**ИРМҮҮН БАР ХХК**

**ЗУРГИЙН ШИФР:**
**ТӨСВИЙН ШИФР:** 2022/80

**ТӨСВИЙН НЭР:** ХӨСҮТ.Барокмерийн өрөөний урсгал засварын ажлын төсөв

**ТӨСӨВТ ӨРТӨГИЙН ДҮН:** 27 508 822 төгрөг
**ТӨСВИЙГ ГҮЙЦЭТГЭСЭН:**

**МЭРГЭШСЭН ТӨСӨВЧИН:** **Л.БААСАНГАРАВ**

**ТАЙЛБАР:** Барилгын төсвийн **"ESTIMATOR-PRO"** программаар хийв.

***УЛААНБААТАР ХОТ 2022 ОН***

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

| Д/Д | Зардлын нэр | Бүгд өртөг /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | **Ажиллах хүчний зардал** | 7,530,218 |
| 2 | **Материал** | 10,015,952 |
| 3 | **Тээвэр** | 38,727 |
| 4 | **Машин ашиглалт** | 685,452 |
| | **Шууд зардлын дүн** | 18,270,350 |
| 5 | **Нэмэгдэл зардал /61 %/** | 2,346,773 |
| 6 | **Ашиг / 15%/** | 3,092,568 |
| | **Барилга угсралтын ажлын дүн** | 23,709,691 |
| 7 | **НӨАТ 10%** | 2,370,969 |
| 8 | **Нормчлолын сан 0.18%** | 42,677 |
| | Дүн | 26,123,338 |
| 9 | **Захиалагчийн албаны зардал** | 474,194 |
| 10 | **Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн** | 200,000 |
| 11 | **Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал** | 237,097 |
| | Дүн | 27,034,628 |
| 12 | **Магадлашгүй ажил 2%** | 474,194 |
| 13 | **Бусад нэмэлт зардал** | 0 |
| | Дүн | 27,508,822 |

## ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

**БУУЛГАХ АЖИЛ**

| Үндэслэл | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах) | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зэрэг | Нэгж хүн-цаг | Бүгд хүн-цаг | Тарифт цалин | Нийт цалин | Бүгд цалин |
| 35-190-06 | Дотор хананд суулгасан хаалга буулгах | м2 | 8 | 2.3 / 2 | 1.13 / 0.04 | 9.047 / 0.31 | 5493 / 5212 | 49696 / 1626 | 51,322 |
| 57-050-05 | Вааран хавтанцараар хийсэн ханын өнгөлгөөг буулгах | м2 | 23.4 | 3.0 / 2 | 0.48 / | 11.326 / | 6150 / 5212 | 69652 / | 69,652 |
| 57-050-10 | Вааран хавтанцараар хийсэн шалны өнгөлгөөг буулгах | м2 | 5.5 | 3.0 / 2 | 0.18 / 0.00 | 1.018 / 0.01 | 6150 / 5212 | 6258 / 29 | 6,286 |
| 53-140-01 | Шалны хуучин хулдаас хуулах | м2 | 45 | 2.0 / 2 | 0.09 / | 4.14 / | 5212 / 5212 | 21578 / | 21,578 |
| 70-130-01 | Таазанд буудаж тогтоосон бэхэлгээтэй өдрийн гэрэлтүүлэгч буулгах | ш | 6 | 2.7 / 2 | 1.38 / 0.05 | 8.28 / 0.3 | 5868 / 5212 | 48587 / 1564 | 50,151 |
| 70-140-02 | Далд суурилсан унтраалга, розетка буулгах | 100ш | 0.23 | 2.5 / 2 | 15.14 / 0.08 | 3.482 / 0.02 | 5680 / 5212 | 19779 / 96 | 19,875 |
| 57-190-03 | Хуучин будагтай ханын гадаргуу 25% хусаж цэвэрлэх | м2 | 20.9 | 2.0 / 2 | 0.25 / | 5.162 / | 5212 / 5212 | 26906 / | 26,906 |
| 57-190-03 | Хуучин будагтай амалгааны гадаргуу 25% хусаж цэвэрлэх | м2 | 2.7 | 2.0 / 2 | 0.25 / | 0.667 / | 5212 / 5212 | 3476 / | 3,476 |
| 55-100-01 | Тавиуртай цонх задалж буулгах | м2 | 12.7 | 2.0 / 2 | 2.63 / 0.15 | 33.35 / 1.9 | 5212 / 5212 | 173821 / 9929 | 183,750 |
| 35-110-04 | Хана ба шаланд 20 см2 хүртэл огтлолтой ховил ухаж гаргах | 100м | 0.2 | 2.6 / 2 | 0.41 / | 0.082 / | 5774 / 5212 | 474 / | 474 |
| 65-010-04 | 64см зузаантай хананд гараар нэвт нүх гаргах. 25мм-ээс дээш голчтой | 1 нүх | 1 | 2.0 / 2 | 6.57 / 0.58 | 6.571 / 0.58 | 5212 / 5212 | 34248 / 3023 | 37,271 |
| 59-080-01 | Өрөө тасалгааны хог цэвэрлэх | м2 | 45 | 1.0 / 2 | 0.07 / 0.01 | 3.24 / 0.54 | 4272 / 5212 | 13841 / 2814 | 16,656 |
| 59-080-10 | Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд экскаватораар ачих | м3 | 2.5 | 2.0 / 2 | 0.04 / | 0.103 / | 5212 / 5212 | 534 / | 534 |

*Нийт Хүн/цаг:* 86.47 / 3.66 *Үндсэн цалин:* 487,931

*Инженер техникийн ажилчдын цалин:* 82,948

*Нэмэгдэл цалин:* 180,534

*Нийт цалин:* 751,413

*Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн:* 101,441

*Ажлын багаж, хувцас, хэрэгсэл:* 102,192

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

*Ажиллах хүчний зардал:* **955,046**

**ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ**

| Үндэслэл | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах) | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зэрэг | Нэгж хүн-цаг | Бүгд хүн-цаг | Тарифт цалин | Нийт цалин | Бүгд цалин |
| 10-120-04 | Тоосгон ханатай барилгын давхар рамтай хуванцар цонх угсрах | м2 | 8.9 | 3.3 / 2 | 1.99 / 0.38 | 17.692 / 3.38 | 6381 / 5212 | 112895 / 17627 | 130,522 |
| 10-180-06 | Дотор хаалга угсрах | м2 | 1.89 | 3.4 / 2 | 1.21 / 0.37 | 2.278 / 0.7 | 6459 / 5212 | 14711 / 3645 | 18,356 |
| 15-730-04 | Хавтанцарыг /плита/ өнгөлгөөний хананд цавуугаар наах | м2 | 23.4 | 3.5 / 2 | 2.31 / 0.00 | 54.038 / 0.07 | 6536 / 5212 | 353190 / 366 | 353,556 |
| 10-570-05 | Таазанд ламиран хавтан өнгөлгөө хийх | м2 | 5.5 | 2.5 / 2 | 3.22 / 0.02 | 17.697 / 0.11 | 5680 / 5212 | 100521 / 556 | 101,077 |
| 11-370-04 | Хавтанцарыг /плита/ бетон шаланд цавуугаар наах | м2 | 5.5 | 2.9 / 2 | 1.93 / 0.03 | 10.61 / 0.15 | 6056 / 5212 | 64251 / 774 | 65,025 |
| 08-190-04 | Цонхны чулуун тавиур хавтан суулгах | м2 | 2.1 | 3.4 / 2 | 1.59 / 0.48 | 3.347 / 1.02 | 6459 / 5212 | 21620 / 5296 | 26,916 |
| 10-180-06 | Метал вакум хаалга угсрах | м2 | 3.2 | 3.4 / 2 | 1.21 / 0.37 | 3.856 / 1.18 | 6459 / 5212 | 24908 / 6171 | 31,079 |
| 10-660-07 | Төмөр каркастай гипсэн хавтангаар гэрэлтүүлгийн нуухтай гоёлын тааз угсрах | м2 | 45 | 3.7 / 2 | 3.21 / 0.1 | 144.45 / 4.46 | 6690 / 5212 | 966370 / 23219 | 989,590 |
| 10-590-04 | Төмөр хаалга суулгах | ш | 1 | 3.0 / 2 | 7.77 / 0.15 | 7.77 / 0.15 | 6150 / 5212 | 47787 / 798 | 48,585 |
| 15-240-09 | Замаскан тэгшилгээ хийх | м2 | 83.4 | 3.6 / 2 | 0.19 / 0 | 15.979 / 0.06 | 6613 / 5212 | 105672 / 304 | 105,976 |
| 15-240-09 | Замаскан тэгшилгээ амалгаанд хийх | м2 | 10.6 | 3.6 / 2 | 0.19 / 0 | 2.031 / 0.01 | 6613 / 5212 | 13431 / 39 | 13,469 |
| 15-180-10 | Шавардсан ба бетон хана энгийн тосон будгаар гараар будах | м2 | 83.4 | 2.9 / 2 | 0.27 / 0.00 | 22.852 / 0.13 | 6056 / 5212 | 138389 / 652 | 139,041 |
| 15-180-10 | Амалгаа энгийн тосон будгаар гараар будах | м2 | 10.6 | 2.9 / 2 | 0.27 / 0.00 | 2.904 / 0.02 | 6056 / 5212 | 17589 / 83 | 17,672 |
| 51-020-01 | Амалгааны тоосгон ханын гадаргуут засах | м2 | 10.6 | 3.0 / 2 | 2.68 / 0.44 | 28.387 / 4.7 | 6150 / 5212 | 174579 / 24475 | 199,053 |
| 15-240-09 | Замаскан тэгшилгээ таазанд хийх | м2 | 45 | 3.6 / 2 | 0.19 / 0 | 8.622 / 0.03 | 6613 / 5212 | 57017 / 164 | 57,181 |
| 57-060-04 | Тааз эмульс будгаар өнхрүүлгээр сайн чанартай будах | м2 | 45 | 3.4 / 2 | 0.67 / 0.00 | 30.195 / 0.09 | 6459 / 5212 | 195030 / 469 | 195,499 |
| 11-250-06 | Тусгай зориулалтын шалны гадаргууд 3мм зузаан тэгшилгээ хийх | м2 | 45 | 3.0 / 2 | 0.32 / 0.06 | 14.603 / 2.88 | 6150 / 5212 | 89805 / 15011 | 104,816 |
| 11-230-04 | Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх | м2 | 45 | 2.9 / 2 | 0.78 / 0.01 | 35.321 / 0.58 | 6056 / 5212 | 213901 / 3049 | 216,950 |
| 10-670-06 | Хаалганд хаалга тайвшруулагч угсрах | иж бүрдэл | 2 | 3.5 / 2 | 1.96 / 0.01 | 3.914 / 0.02 | 6536 / 5212 | 25582 / 115 | 25,697 |
| 15-690-32 | Сараалж далавч радиатор будах | м2 | 4 | 2.5 / 2 | 0.44 / 0.07 | 1.76 / 0.27 | 5680 / 5212 | 9997 / 1397 | 11,394 |
| 20-260-08 | Таазанд далд суух ус чийгний хамгаалалтай | ш | 6 | 2.8 / 2 | 1.74 / 0.00 | 10.44 / 0.01 | 5962 / 5212 | 62243 / 31 | 62,275 |

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өдрийн гэрэлтүүлэгч 60*60 угсрах | | | | | | | | |
| 20-260-08 | Таазанд далд суух ус чийгний хамгаалалтай өдрийн гэрэлтүүлэгч 40*40 угсрах | ш | 2 | 2.8 / 2 | 1.74 / 0.00 | 3.48 / 0.00 | 5962 / 5212 | 20748 / 10 | 20,758 |
| 38-270-61 | Зэс дамжуулагчтай 4мм2 огтлолтой утас татах | м | 20 | 3.0 / 2 | 0.21 / 0.00 | 4.16 / 0.09 | 6150 / 5212 | 25584 / 448 | 26,032 |
| 38-270-61 | Зэс дамжуулагчтай 6мм2 огтлолтой утас татах | м | 60 | 3.0 / 2 | 0.21 / 0.00 | 12.48 / 0.26 | 6150 / 5212 | 76752 / 1345 | 78,097 |
| 39-120-30 | Зэс хоолой дамжуулагч | 1 м | 50 | 5.0 / 2 | 0.54 / 0.02 | 27 / 1 | 7604 / 5212 | 205308 / 5212 | 210,520 |
| 16-110-04 | Зэс хоолойн өмөлгөн хаалт голч d=20мм байрлуулах | ш | 2 | 3.6 / 2 | 1.49 / 0.02 | 2.981 / 0.04 | 6613 / 5212 | 19712 / 219 | 19,931 |
| 38-520-39 | Далд угсралтын унтраалга угсрах | ш | 3 | 3.0 / 2 | 0.25 / 0.03 | 0.75 / 0.09 | 6150 / 5212 | 4613 / 469 | 5,082 |
| 38-520-07 | Розетка далд угсрах | ш | 20 | 3.0 / 2 | 0.35 / 0.03 | 7 / 0.6 | 6150 / 5212 | 43050 / 3127 | 46,177 |
| 16-270-04 | Бохир усны хуванцар хоолой d-50 | м | 6 | 4.0 / 2 | 0.94 / 0.00 | 5.616 / 0.01 | 6921 / 5212 | 38868 / 44 | 38,913 |

*Нийт Хүн/цаг:* 502.21 / 22.09 *Үндсэн цалин:* 3,359,238

*Инженер техникийн ажилчдын цалин:* 571,071

*Нэмэгдэл цалин:* 1,242,918

*Нийт цалин:* 5,173,227

*Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн:* 698,386

*Ажлын багаж, хувцас, хэрэглэл:* 703,559

*Ажиллах хүчний зардал:* **6,575,171**

Бүгд хүн/цаг: ***588.68 / 25.75*** Бүгд цалин: ***3,847,169***

Инженер техникийн ажилчдын цалин: **654,019**

Нэмэгдэл цалин: **1,423,453**

Нийт цалин: **5,924,640**

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн: **799,826**

Ажлын багаж, хувцас, хэрэглэл: **805,751**

Ажиллах хүчний зардал: **7,530,218**

## НИЙТ БАРИЛГЫН МАШИН МЕХАНИЗМЫН ХЭРЭГЦЭЭ

| Шифр | Машин механизмын нэр | Нийт хэрэгцээ | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | Таслагч | 44.55 | 50 | 2,228 |
| 3027 | Цахилгаан өрөм | 43.2 | 2531 | 109,339 |
| | Шурупдэгч машин | 63.55 | 7000 | 444,850 |
| 1006 | Экскаватор 0.15м3 | 0.6 | 20700 | 12,420 |
| 2028 | Автокран 5тн | 1.94 | 59489 | 115,582 |
| | Автомашин | 0.3 | 3453 | 1,034 |
| | | | | 685,452 |

## МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

| Шифр | Материалын нэр | Материал | | | | Тээвэр | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Х/Н | Үнэ | Нийт орц | Зардал | Нийт жин | Зай | Зэрэг | Тариф | Зардал |
| 1-5031 | Cw хэлбэрийн төмөр | м | 3000 | 321.3 | 963900 | 0.0964 | 10 | 1 | 348.9 | 336 |
| 3-5472 | Розетка далд | ш | 5500 | 20.4 | 112200 | 0.0082 | 10 | 2 | 461.73 | 38 |
| 1-4542 | Уулын элс | м3 | 5000 | 0.4329 | 2164 | 0.6493 | 0 | 1 | 0 | 0 |
| 3-6422 | Таазанд далд суух ус чийгний хамгаалалтай өдрийн гэрэлтүүлэгч 60*60 | ш | 25000 | 8 | 200000 | 0.096 | 10 | 2 | 461.73 | 443 |
| 1-4412 | Тоосгон ханатай барилгын давхар рамтай хуванцар цонх | м2 | 175000 | 8.9 | 1557500 | 0.5757 | 10 | 2 | 461.73 | 2,658 |
| | Төмөр хаалга | ш | 350000 | 1 | 350000 | 0.1 | 10 | 2 | 461.73 | 462 |
| 1-0292 | Хулдаас | м2 | 22000 | 45.9 | 1009800 | 0.3553 | 10 | 2 | 461.73 | 1,640 |
| 1-0370 | Хулдаас наах түрхлэг | кг | 9000 | 13.5 | 121500 | 0.0153 | 10 | 2 | 461.73 | 70 |
| 2-1136 | Холбох хэрэгслэлүүд | ш | 4500 | 1.86 | 8370 | 0.0000 | 10 | 2 | 461.73 | 0 |
| 1-0095 | Хадаас /70-110мм/ | кг | 2600 | 0.576 | 1498 | 0.0007 | 10 | 2 | 461.73 | 3 |
| 1-5200 | Хаалга тайвшруулагч | ком | 24000 | 2 | 48000 | 0.006 | 10 | 1 | 348.9 | 21 |
| 1-4288 | Хавтанцар /плита/ 30x30 | м2 | 25000 | 31.212 | 780300 | 0.0393 | 10 | 1 | 348.9 | 137 |
| 1-4335 | Хөвөө мод | м | 1300 | 49.95 | 64935 | 0.0402 | 10 | 1 | 348.9 | 140 |
| 1-4255 | Цонхны чулуун тавцан | м | 36000 | 6.111 | 219996 | 1.0755 | 10 | 1 | 348.9 | 3,753 |
| 4-0021 | Царуцан хөрсжүүлэгч | кг | 2700 | 742.5 | 2004750 | 0.7425 | 10 | 1 | 348.9 | 2,591 |
| 1-0185 | Цавуу | кг | 6000 | 3.74 | 22440 | 0.0045 | 10 | 2 | 461.73 | 21 |
| 1-0071 | Цаасан зүлгүүр | м2 | 4500 | 1.2992 | 5846 | 0.0023 | 10 | 2 | 461.73 | 10 |
| 1-4029 | Цемент м-300 | тн | 528000 | 0.0337 | 17811 | 0.0344 | 0 | 1 | 0 | 0 |
| 1-4028 | Цемент м-400 | тн | 350000 | 0.027 | 9458 | 0.0276 | 0 | 1 | 0 | 0 |
| 1-0861 | Шураг | кг | 2800 | 0.4 | 1120 | 0.0005 | 10 | 2 | 461.73 | 2 |
| 1-4529 | Шохой | тн | 400000 | 0.0222 | 8868 | 0.027 | 0 | 1 | 0 | 0 |
| 1-0363 | Шүршдэг хөөс | кг | 8000 | 0.75 | 6000 | 0.0009 | 10 | 2 | 461.73 | 4 |
| 1-0182 | Эпоксид цавуу | кг | 6000 | 3.475 | 20850 | 0.0042 | 10 | 2 | 461.73 | 19 |
| 1-1296 | Эмульс | кг | 8000 | 25.74 | 205920 | 0.0332 | 10 | 2 | 461.73 | 153 |
| 1-4567 | Янз мод | м | 3200 | 27.3079 | 87385 | 0.0267 | 10 | 1 | 348.9 | 93 |
| 2-2809 | Бохир усны хуванцар хоолой d-50 | м | 12000 | 6.12 | 73440 | 0.0015 | 10 | 3 | 619.12 | 9 |
| 1-0136 | Бэхэлгээ төмөр | кг | 3000 | 0.798 | 2394 | 0.0008 | 10 | 2 | 461.73 | 4 |
| 1-0864 | Гипс шуруп | кг | 3800 | 3.555 | 13509 | 0.0036 | 10 | 1 | 348.9 | 12 |

## МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

| Шифр | Материалын нэр | Материал | | | | Тээвэр | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Х/Н | Үнэ | Нийт орц | Зардал | Нийт жин | Зай | Зэрэг | Тариф | Зардал |
| 1-4256 | Ердийн тоосго м-75 | 1000ш | 550000 | 0.5512 | 303160 | 2.191 | 15 | 1 | 334.65 | 10,998 |
| 1-5032 | Ердийн гипс хавтан | м2 | 2500 | 68.85 | 172125 | 0.6196 | 10 | 1 | 348.9 | 2,162 |
| 3-5117 | Далд унтраалга | ш | 4545 | 3 | 13635 | 0.003 | 10 | 2 | 461.73 | 14 |
| 1-0128 | Дюбельтэй хадаас | кг | 1500 | 2.16 | 3240 | 0.0000 | 10 | 2 | 461.73 | 0 |
| 1-4151 | Дүнзэнцэр 5*5 | м3 | 140000 | 0.0336 | 4697 | 0.0218 | 10 | 1 | 348.9 | 76 |
| 1-0134 | Дибаз, андезит, кварц, полимер шаваас | кг | 7000 | 0.3087 | 2161 | 0.0004 | 10 | 2 | 461.73 | 2 |
| 1-5111 | Заадасны лент/ бандаж/ | м | 150 | 113.85 | 17078 | 0.0017 | 10 | 1 | 348.9 | 6 |
| 1-0134 | Замаск | кг | 400 | 217.158 | 86863 | 0.2736 | 10 | 2 | 461.73 | 1,263 |
| | Зам төмөр | м | 22040 | 10.23 | 225469 | 0.0082 | 10 | 2 | 461.73 | 38 |
| 2-2320 | Зэс хоолой ф15мм | м | 1395 | 50 | 69750 | 0.05 | 10 | 3 | 619.12 | 310 |
| 2-0100 | Зэс хоолойн өмьөлгөн хаалт голч d=20мм | ш | 34000 | 2 | 68000 | 0.0081 | 10 | 2 | 461.73 | 37 |
| 3-2864 | Зэс дамжуулагчтай 4мм2 огтлолтой утас | км | 2080000 | 0.0206 | 42848 | 0.0134 | 10 | 2 | 461.73 | 62 |
| 3-2864 | Зэс дамжуулагчтай 6мм2 огтлолтой утас | км | 2100000 | 0.0618 | 129780 | 0.0403 | 10 | 2 | 461.73 | 186 |
| | Лампир | м2 | 25000 | 7.15 | 178750 | 0.0123 | 10 | 2 | 461.73 | 57 |
| 1-4325 | Модон хаалга | м2 | 85000 | 5.09 | 432650 | 1.9973 | 10 | 2 | 461.73 | 9,222 |
| 1-0221 | Энгийн тосон будаг | кг | 6500 | 23.876 | 155194 | 0.0308 | 10 | 2 | 461.73 | 142 |
| 1-0220 | Энгийн будаг | кг | 6500 | 0.8 | 5200 | 0.001 | 10 | 2 | 461.73 | 5 |
| 1-5035 | Өлгүүр хийц | ш | 200 | 315 | 63000 | 0.189 | 10 | 1 | 348.9 | 659 |
| 1-5036 | Өлгүүр хийц бэхлэх бэхлэгч | ш | 200 | 315 | 63000 | 0.126 | 10 | 1 | 348.9 | 440 |
| 1-5030 | Uw хэлбэрийн төмөр | м | 1133 | 52.425 | 59398 | 0.0157 | 10 | 1 | 348.9 | 55 |
| | | | | | Хог, хаягдлын зардал | 0.0574 | 20 | 1 | 323.62 | 372 |
| | | | | | 10,015,952 | | | | | 38,727 |